

Газар эзэмших эрхийн нэр
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн нэр шилжүүлэхээр хүсэлт гаргасан 15 /арван тав/ иргэний газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэн хавсралтаар баталгаажуулсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэн баталгаажуулсан 2008 оны A/150 дугаар захирамжийн Пүрэвдорж Амгаланзаяа, 2014 оны A/217 дугаар захирамжийн Батбаатар Алтанчимэг, 2003 оны A/121 дүгээр захирамжийн Сүрэнжав Чулуунбаатар, 2003 оны A/121 дүгээр захирамжийн Чулуунбаатар Мөнхбаяр, 2016 оны A/326 дугаар захирамжийн Гонгор Одгэрэл, 2014 оны A/409 дүгээр захирамжийн Түвшинжаргал Түмэннаст, 2011 оны A/121 дүгээр захирамжийн Ломбо Амарбаясгалан, 2007 оны A/186 дугаар захирамжийн Ядамсүрэн Батсуурь, Батсуурь Оюунгэрэл, Батсуурь Оюунбилэг, Цэрэндолгор Алтанцэцэг, 2008 оны A/204 дүгээр захирамжийн Шархүү Бүжхүү, 2014 оны A/296 дугаар захирамжийн Жүгдэр Отгонтуяа, 2015 оны A/497 дугаар захирамжийн Сэргээнэв Баянмөнх, 2008 оны A/122 дугаар захирамжийн Наарай Баянмөнх нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх шилжүүлэн авсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ